- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот ‘’бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай’’*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот ‘’төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Мал эмнэлгийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ХХАА-н яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор МЭЕГ-ын дотоод хяналтыг 2020 онд тус байгууллагад хэрэгжүүлээгүй ч аймгийн МЭГ-аас сумдын нэгжүүдэд хяналт хийсэн мөн аймгийн Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1237542.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 12375.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 2037451.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 20374.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 351399.9 мянган төгрөгөөр буюу 20.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| АВЛАГА | 24,603.2 | 55,000.0 | 30,396.8 |
| БАРАА МАТЕРИАЛ | 351,515.10 | 577,313.30 | 225,798.2 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 728,215.4 | 823,420.3 | 95,204.9 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,104,333.7** | **1,455,733.6** | **351,399.9** |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР | 0.0 | 1,766.3 | 1,766.3 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН | 1,104,333.7 | 1,453,967.3 | 349,633.6 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР** | **1,104,333.7** | **1,455,733.6** | **351,399.9** |

Авлага дансны үлдэгдэл 55000.0 мянган төгрөг болж 30396.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төслийн хөрөнгө оруулалттай холбоотой урьдчилж гарсан зардал нэмэгдэж өмнөх оны төсвийн хэмнэлтийн 24603.2 мянган төгрөгийн авлага нэмэлт санхүүжилтээр бүрэн орж ирж зарцуулагдсан байна.

Тайлант онд хувь хүн, аж ахуйн нэгжтэй холбоотой тооцоо хийгээгүй, өглөг авлага тооцоогүй, бараа материалын хоорондын тооцоо хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 486123.0 мянган төгрөг болж 134608.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн малын эмэг, лабораторийн багаж, ариутгалын бодисын үлдэгдэл нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 728215.4 мянган төгрөг, оны эцэст 896296.0 мянган төгрөг болж 168080.6 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь МЭЕГ-аас 184558.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 100000.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, 2020 оны 07 сарын 08-ны 131 тоот ИТХ-ын тогтоолоор 13622.2 мянган төгрөгийн мал угаалгын ванн Булган суманд давхар орлого авсан хөрөнгийг буурулсан байна.

Өр төлбөр оны эхэнд байхгүй тайлант оны эцэст 1766.3 мянган төгрөгийн өр бүртгэсэн байгаа нь төсвийн хөрөнгийн үргүй зардал гаргаж төсвийн хэмнэлт гаргаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1435652.8 мянган төгрөг болж тайлант 331319.1 мянган төгрөгөөр буюу цэвэр хөрөнгийн дүнгээр өсгөсөн байгаа нь тайлангийн үнэн зөв байдалтай нийцээгүй байгааг залруулж бичилт хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 304424.9 мянган төгрөгөөр буюу 30.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 304424.9 мянган төгрөгийн орлогоос үнэ төлбөргүй орлого 304424.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 464332.7 мянган төгрөгөөр буюу 68.6 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 464332.7 мянган төгрөгийн зардал нь цалингийн зардал 24373.7 мянган төгрөгөөр, БГАҮ-ний зардал 240391.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 199567.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 4256.9 мянган төгрөг бичигдсэн нь элэгдэлтэй хөрөнгө акталсантай холбоотой хөрөнгийн элэгдэл бичигдсэнийг залруулж үндсэн хөрөнгийн гарзаар бүртгүүлсэн.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 761335.9 мянган төгрөгөөр нийт зарлагыг 761335.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

МЭЕГ-аас үндсэн үйл ажиллагааны зардалд 848103.2 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 3000.0 мянган төгрөгөөр нийт 851103.2 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн боловч төсвийн хуваарь 3 удаа өөрчлөгдсөн өөрчлөлт хийгдсэн төсвийн хуваарь албан ёсоор баталгаажаагүй байна.

### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 761335.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 761335.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 848103.2 мянган төгрөгийн санхүүжилт, 3000.9 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 841735.8 мянган төгрөгийг зарцуулж 9367.4 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 841735.8 мянган төгрөг буюу 95% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөр бүрээс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 8,082,832 |
| 80802 | Тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж | 62,230 |
| 82502 | Мал эмнэлгийн үйлчилгээ | 1,168,140 |
| 82508 | Мал эмнэлгийн газар | 54,250 |
| | **ДҮН** | **9,367,452** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас мал хөтөлбөр арга хэмжээнд 100000.0 мянган төгрөг, МЭУС зардлын санхүүжилт 280321.9 мянган төгрөг, өмнөх оны хэмнэлтээс 26589.6 мянган төгрөг, төсөл хөтөлбөрөөс 55904.0 мянган төгрөг, вакцины зардалд 180655.1 мянган төгрөг, бусад 35181.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос мал хөтөлбөрийн хүрээнд малын эмэг, тоног төхөөрөмж авах 100000.0 мянган төгрөг, МЭУСЗ болон бусад ариутгалын бодис авахад 280321.9 мянган төгрөг, малын вакцины үнэнд 180655.1 мянган төгрөг, бусад аж ахуйн зардалд 34684.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж 497.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 126 мэдээллээс хугацаандаа оруулсан 22 мэдээллийг огт оруулаагүй, 2 мэдээлэл дутуу мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулснаас санхүүжилтийн орлогын мэдээллийг байршуулаагүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Мал эмнэлгийн газар нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 2 | 3,060.0 | 1 | 3,060.0 | 1 | - | 60% |
| Нийт дүн | 2 | 3,060.0 | 1 | 3,060.0 | 1 | - | 60% |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 414180.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 60758.0 мянган төгрөгийн алдаа залруулж 9331.5 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож 214235.6 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 албан шаардлага, 129854.9 мянган төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

**<u>Залруулсан алдаа</u>:** Аудитаар тайлант хугацааны үнэ төлбөргүй орлого болон үйл ажиллагаатай холбоотой орлого дутуу бүртгэсэн 29558.0 мянган төгрөгийн орлогыг үр дүн мөнгөн хөрөнгийн тайланд, барилгын зураг хийсэн зургийн орлогыг бүртгээгүй 31200.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд орлого бүртгэх залруулга хийгдсэн.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 353422.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9331.5 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож 214235.6 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

### *1. Өглөг, авлагатай холбоотой*

1.1. *<u>Илрүүлэлт:</u>* Цалингаас суутгасан хүн амын орлогын албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй 233.6 мянган төгрөг,
*<u>Илрүүлэлт:</u>* Байгууллагын даргын тушаалаар суутгасан суутгалыг дутуу суутгасан тушаалын биелэлт хангалтгүй 837.7 мянган төгрөг,
*<u>Илрүүлэлт:</u>* Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтаар мэргэжлийн хүн ажиллах албан тушаалд сонгон шалгаруулалт явуулаагүй, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын сонгон шалгаруулалтад тэнцсэн мэргэжлийн бус, тэтгэвэрт гарсан хүн ажиллаж өмнө авч байсан удаан жил, зэрэг дэвийн нэмэгдэл олгож төсвийн үргүй зардал гаргасан 4770.2 мянган төгрөг,
*<u>Илрүүлэлт:</u>* Махны нөөц бэлтгэх үлдэгдэл үнэ гэж төрийн банкны түр дансаар гарсан мөнгө тооцоо хийж баталгаажуулаагүй анхан шатны баримт дутуу өглөг авлагаар тусгагдаагүй зардал шилжүүлсэн 3490.0 мянган төгрөгийн зөрчлүүд тус тус илэрлээ.

1.2. *<u>Эрсдэл:</u>* Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, төсөв хэтрүүлэн зарцуулсан байх, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх бодит байдал хангагдахгүй байх

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>: Төлбөрийн акт тогтоох*

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>* Хүлээн зөвшөөрсөн

### *2. Мөнгөн хөрөнгө, төсөвтэй холбоотой*

*2.1.* *<u>Илрүүлэлт:</u>* МЭУСЗ-ын сумдын санхүүжилтийг батлагдсан төсвөөс тогтоол шийдвэргүй илүү олгож төсөв хэтрүүлсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй тарифаар МЭ-ийн үйлчилгээний хөлсийг нэмж санхүүжилт баталсан, УТ-өөс санхүүждэг томуугийн тарилгын үйлчилгээний хөлсийг ОН-ийн төсөвт баталж зарцуулсан нь төсвийн үр өгөөжийг бууруулсан 80500.0 мянган төгрөг,
*<u>Илрүүлэлт:</u>* МЭЕ-газраас МЭ-ийн газарт 2020 онд 3 удаа төсвийн өөрчлөлт хийж санхүүжилтийг баталж зарцуулсан боловч ХХААЯ-ны сайдын тодотгосон төсвийн тушаал шийдвэргүй, баталгаажуулаагүй төсвийн хуваариар санхүүжилт олгосон, батлагдсан орон тоо 32 байхад цалингийн цэсээр 57 хүн цалин авч байгаа орон тоо илүү, төсөв бодит бус төлөвлөгдсөн, төсвийн бодит үр дүн буурсан 80192.6 мянган төгрөг,
*<u>Илрүүлэлт:</u>* Хувь иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын тооцоо хийж баталгаажуулаагүй, хөрөнгийн орлого, мөнгөн хөрөнгийн зарлага зөрүүтэй, е баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтыг хуулбараар бүрдүүлсэн, өглөг авлага тооцоогүй 28953.4 мянган төгрөг, Өмнөх оны төсвийн хэмнэлтийг авлагаар

тусгаж нэмэлт дансаар санхүүжилт буцаан авсан боловч өмнөх оны өглөг гэж тайлан балaнст тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй
Илрүүлэлт: МЭУСЗ-ийн өглөг аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн, төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан 24589.6 мянган төгрөгийн зөрчлүүд тус тус илэрлээ.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх төсөв хэтрүүлэн зарцуулсан байх, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх бодит байдал хангагдахгүй байх

2.3. *Өгсөн зөвлөмж: Албан шаардлага өгөх*

2.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн.

**Аудитын зөвлөмж:** Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 129854.9 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар болосвролын салбарт олгогдож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн олголт, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3. Хөрөнгийн данстай холбоотой

3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу цэгцлээгүй,
Илрүүлэлт: Төсөл хөтөлбөрөөс МЭҮН-ийн байр засварлах санхүүжилт ирсэн боловч гэрээний гүйцэтгэл байхгүй, хэзээ хүлээлгэн өгөх нь тодорхой бус, явцын хяналт хийгдээгүй ажлын даалгавар, зураг төсөв хийгээгүй 55000.0 мянган төгрөг,
Илрүүлэлт: Аймгийн ОНХС-ийн малын эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт хангалтгүй, зарим ажлууд хийгдээгүй 59750.0 мянган төгрөг,
Илрүүлэлт: Тандалт, судалгаа, хяналт хийх шатахууны зардлыг дээд газраас бүрэн өгсөн байхад төсвийн шатахуун зарцуулалт хэт өндөр үрэлгэн байдлаар зарцуулагдсан, тэвчиж болох зардал хэмнэгдээгүй, шатахуун зарцуулалтын тайлан зөрүүтэй зэрэг зөрчлүүд тус тус илэрлээ.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх

3.3. *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль*

*болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,*

*3.4.* *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

### **4. Мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалттай холбоотой**

*4.1.* *Илрүүлэлт:* МЭУСЗ болон, вакцины зардлын тооцоог аж ахуйн нэгжүүдтэй тооцоо бүрэн хийж актаар баталгаажуулаагүй, МЭУСЗ-ийн хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй зориулалт бус зарцуулсан 5090.0 мянган төгрөг,
*Илрүүлэлт:* Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтаар мэргэжлийн хүн ажиллах албан тушаалд сонгон шалгаруулалт явуулаагүй, тэтгэвэрт гарсан хүн ажиллаж НДШ, болон цалингийн шатлалын зөрүүгээр төсвийн үргүй зардал гаргасан 2964.9 мянган төгрөг,
*Илрүүлэлт:* МЭГ-ын подвал, узель засварын ажил хийхээр 04 тоот гэрээг хувь иргэнтэй хийсэн боловч хүлээн авсан акт байхгүй, хийх ажлын зураг төсөвгүй, ажлын гүйцэтгэл байхгүй, хугацаандаа хүлээлгэн өгөөгүй 3520.0 мянган төгрөг,
*Илрүүлэлт:* Үнэт цаасны тооцоо болох малын гарал үүслийн бичиг болон ахуйн шинжилгээний орлогын тооцоо хийгээгүй, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, дотоод хяналт сул,
*Илрүүлэлт:* Барилгын зураг төсвийн зураг хийлгэх зардалд гарсан зардлыг бүртгэлд тусгаагүй 3800.0 мянган төгрөгийн зөрчлүүд илэрлээ.

*4.2.* *Эрсдэл:* Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хангагдахгүй байх

*4.3.* *Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", ТАЗ-ийн 07 тоот зөвлөмжийн 8-р зүйлд "Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн..үндэслэлээр чөлөөлөгдсөн хүнийг төрийн албаны сонгогддогоос бусад үндсэн албан тушаалд томилон ажиллуулж болохгүй..."гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах*

*4.4.* *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

| Огноо: | Аудитын нэр: | **Мал эмнэлгийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит** | Аудитын код: |
|---|---|---|---|

2021

ХОА-2021/132/СТА-

Шалгагдсан байгууллагын нэр: **Мал эмнэлгийн газар**

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингаас суутгасан хүн амын орлогын албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй | 233.6 | Төлбөрийн акт | Мал эмнэлгийн газрын дарга, Санхүү, албаны дарга, Нягтлан бодогч | Д.Батцэнгэл Ц.Бямбацогт Л.Энхтуул |
| 2 | Байгууллагын даргын тушаалаар суутгасан суутгалыг дутуу суутгасан тушаалын биелэлт хангалтгүй | 837.7 | Төлбөрийн акт | | |
| 3 | Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтаар мэргэжлийн хүн ажиллах албан тушаалд сонгон шалгаруулалт явуулаагүй, ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын сонгон шалгаруулалтад тэнцсэн мэргэжлийн бус, тэтгэвэрт гарсан хүн ажиллаж өмнө авч байсан удаан жил, зэрэг дэвийн нэмэгдэл авч төсвийн үргүй зардал гаргасан | 4770.2 | Төлбөрийн акт | | |
| 4 | Махны нөөц бэлтгэх үлдэгдэл үнэ гэж төрийн банкны түр дансаар гарсан мөнгө тооцоо хийж баталгаажуулаагүй анхан шатны баримт дутуу өглөг авлагаар тусгагдаагүй зардал шилжүүлсэн | 3490.0 | Төлбөрийн акт | | |
| 5 | МЭУСЗ-ын сумдын санхүүжилтийг батлагдсан төсвөөс тогтоол шийдвэргүй илүү олгож төсөв хэтрүүлсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй тарифаар МЭ-ийн үйлчилгээний хөлсийг нэмж санхүүжилт баталсан, УТ-өөс санхүүждэг томуугүйн тарилгын үйлчилгээний хөлсийг ОН- | 80500.0 | Албан шаардлага | | |

| | | | |
|---|---|---|---|
| | ийн төсөвт баталж зарцуулсан нь төсвийн үр өгөөжийг бууруулсан | | |
| 6 | МЭЕ-газраас МЭ-ийн газарт 2020 онд 3 удаа төсвийн өөрчлөлт хийж санхүүжилтийг зарцуулсан боловч ХХААЯ-ны сайдын тодотгосон төсвийн тушаал шийдвэргүй, баталгаажуулаагүй төсвийн хуваариар санхүүжилт олгосон, батлагдсан орон тоо 32 байхад цалингийн цэсээр 57 хүн цалин авч байгаа, орон тоо илүү, төсөв бодит бус төлөвлөгдсөн, төсвийн бодит үр дүн буурсан | 80192.0 | Албан шаардлага |
| 7 | Хувь иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын тооцоо хийж баталгаажуулаагүй, хөрөнгийн орлого, мөнгөн хөрөнгийн зарлага зөрүүтэй, е баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтыг хуулбараар бүрдүүлсэн, өглөг авлага тооцоогүй | 28953.4 | Албан шаардлага |
| 8 | Өмнөх оны төсвийн хэмнэлтийг авлагаар тусгаж нэмэлт дансаар санхүүжилт буцаан авсан боловч өмнөх оны өглөг гэж тайлан балансt тусгагдаагүй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй МЭУСЗ-ийн өглөг аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн, төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулсан | 24589.6 | Албан шаардлага |
| 9 | Үнэт цаасны тооцоо болох малын гарал үүслийн бичиг болон ахуйн шинжилгээний орлогын тооцоо хийгээгүй, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, дотоод хяналт сул байна | 0 | Зөвлөмж |
| 10 | М13ЭУСЗ болон, вакцины зардлын тооцоог аж ахуйн нэгжүүдтэй тооцоо бүрэн хийж актаар баталгаажуулаагүй, МЭУСЗ-ийн хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй зориулалт бус зарцуулсан | 5090.0 | Зөвлөмж |
| 11 | Тандалт, судалгаа, хяналт хийх шатахууны зардлыг дээд газраас бүрэн өгсөн байхад төсвийн шатахуун зарцуулалт хэт өндөр үрэлгэн байдлаар зарцуулагдсан, тэвчиж болох зардал хэмнэгдээгүй, шатахуун зарцуулалтын тайлан зөрүүтэй | 0 | Зөвлөмж |
| 12 | Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу цэгцлээгүй | 0 | Зөвлөмж |
| 13 | Төсөл хөтөлбөрөөс МЭҮН-ийн байр засварлах санхүүжилт ирсэн боловч гэрээний гүйцэтгэл байхгүй, хэзээ | 55000.0 | Зөвлөмж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хүлээлгэн өгөх нь тодорхой бус, явцын хяналт хийгдээгүй ажлын даалгавар, зураг төсөв хийгээгүй | | | | |
| 14 | Аймгийн ОНХС-ийн малын эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт хангалтгүй, зарим ажлууд хийгдээгүй /малын ээмэг/ | 59750.0 | Зөвлөмж | | |
| 15 | МЭГ-ын подвал, узель засварын ажил хийхээр 04 тоот гэрээг хувь иргэнтэй хийсэн боловч хүлээн авсан акт байхгүй, хийх ажлын зураг төсөвгүй, ажлын гүйцэтгэл байхгүй, хугацаандаа хүлээлгэн өгөөгүй | 3250.0 | Зөвлөмж | | |
| 16 | Удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтаар мэргэжлийн хүн ажиллах албан тушаалд сонгон шалгаруулалт явуулаагүй, тэтгэвэрт гарсан хүн ажиллаж шимтгэл, шатлалын зөрүүгээр төсвийн үргүй зардал гаргасан | 2964.9 | Зөвлөмж | | |
| 17 | Өмнөх оны барилгын зураг төсвийн зардлыг эргэн тооцоогүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй | 3800.0 | Зөвлөмж | | |
| 18 | Үр дүн, мөнгөн гүйлгээний орлого дутуу тайлагнасан, үйл ажиллагааны орлого зөрүүтэй илэрхийлэгдсэн | 29558.0 | Залруулсан | | |
| 19 | Өмнөх оны барилгын зураг төсвийн зардлыг эргэн тооцоогүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй | 31200.0 | Залруулсан | | |
| **ДҮН** | | **414180.0** | | | |

**ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**